을 수 있다고 한다. 왕 홍 리氏는 거란어의 ≪쥐≫를 위구르어의 '쥐' ≪洗尺罕≫(高昌館朶字)와 기원이 같고 [ʃaʤkan] 또는 [saʤkan]으로부터 변화를 겪어 sarga가 되었다고 한다. 이러한 견해는 상당히 주목할 만한 것이지만 현재로서는 단정적으로 이야기하기가 어려운 것으로 보인다. 그러나 분명한 것은 이 단어의 발음이 몽골어와는 완전히 다르다는 사실이다.

위에서 언급한 것들을 대강 정리하면 거란어의 十二支 명칭 가운데 '용, 닭, 말, 뱀, 토끼, 개, 양(염소), 소(암소)' 등의 여덟 개는 몽골어와 동일하거나 대체로 동일하다. '호랑이'의 발음은 상이하지만 몽골어로 해독할 수 있다. 그러나 나머지 '개, 원숭이, 쥐' 셋은 몽골어와는 완전히 상이하다. 이러한 상황은 몽골어와 거란어의 공통점과 차이점, 그리고 두 언어 사이의 상호관계를 일부 보여주는 것으로 생각된다.

(번역: 강 신(단국대))

Кидан хэл хийгээд монгол хэлний арван хоёр жил

Чингэлтэй (Өвөр монголын их сургууль)

Монгол хэлэнд хулгана, үхэр, барс, туулай гэх мэтийн 12 жил буюу 12 эрхтний нэр байхын адилаар кидан хэлэнд ч адил утгатай 12 эрхтний нэр байжээ. Хүмүүсийн төрсөн жилийг илтгэдэг 12 эрхтний нэр нь утгын талаар адил боловч дуудлагын талаар арай адил биш. Иймээс эдгээр 12 эрхтны кидан хэлэн дахь дуудлагыг мэдэж авах нь монгол кидан хэлний хоорондын адил тал зөрөөтэй талыг мэдэж хоёр хэлний харьцаа холбоог мэдэхэд чухал ач холбогдолтой тул судлаачдын анхаарлыг татсаар ирсэн юм.

Манайхан ч энэ асуудлыг судлаад ирсэн бөгөөд 70-аад оноос эхлэн ойрын үе болтол өдий төдий амжилтыг олсон байна. Эдгээр амжилт ба судалгааны үр бүтээлийг товоор танилцуулбал доорхи мэт болно.

Нэг. Кидан хэлний материал хийгээд киданаар бичигдсэн материалыг харгагуулан судалж байх явцад ≪луу≫-г кидан хэлний бага үсгээр 𗼇 гэж бичиж байхыг мэджээ. Энэхүү кидан үсэг нь 𗼇 [ŋim siŋ kuɑŋ lu tɑi fu] (銀青光祿大夫) гэх мэтийн хятад хэлнээс зээлсэн үгэн дотор ≪луу≫ гэсэн дуудлагатай тул кидан хэл хийгээд монгол хэл нь энэ үгийг адилаар ≪луу≫ гэж дуудах нь мэдээж.

Хоёр. Кидан бага үсэг хийгээд хятад үсгийн материалаас ≪хонь≫ нь 羊为 гэж бичиж байгаа нь мэдэгджээ. 羊үсэг нь [ем] дуудлагатай. Жишээ нь 们 九习 尤 [tu kiem] (都檢). 为 нь [a] дуудлагатай. Жишээ нь 个 又为 [fu mɑ] (附馬). Иймээс монгол хэлний хонийн оронд кидан хэлэнд [ема] (ямааг)-г хэрэглэдэг юм байжээ.

Гурав. ≪Нохой≫ гэх үг нь киданы бага үсгээр 伏为 гэж бичиж байх бөгөөд хятадаар бичсэн түүхийн тэмдэглэлд кидан хэлэнд ≪нохой≫-г 揑褐 (niehe) гэж дуудна гэж тэмдэглэсэн зүйл бий. 伏 нь [ən]~[nə] болохыг өнгөрсөн судалгаанаас мэдсэн тул (бодитой баримтыг товчилъя) бүхэл үг нь [nəxəi] буюу [noxi] гэж төсөөлж болно. Энэ нь монгол хэлний ≪нохой≫ гэсэн дуудлагатай төстэй.

Дөрөв. ≪Тахиа≫ гэх үгийг кидан бага үсгээр 令为 为 гэж бичиж байдаг. Нэгдүгээр үсэг нь tɑ буюу t'ɑ болохыг нэгэнт мэдсэн (бодитой жишээг товчлов). Хоёрдугаар үсэг нь өмнөх жишээнээс их төлөв [xəi] буяюу [xi] гэж төсөөлж болмой. Гуравдугаар үсэг нь [ɑ] болохыг нэгэнт мэдсэн. Иймээс бүхэл үг нь [t'ɑxəiɑ] буюу [tɑxiɑ] гэж дуудаж болно. Энэ нь харин монгол хэлний тахиа гэсэн дуудлагатай бараг адилхан болжээ.

Тав. ≪Туулай≫ гэх үгийг киданы бага үсгээр 支先为 гэж бичдэг. Хятадаар бичсэн түүхийн тэмдэглэлд кидан хэлэнд ≪туулай≫-г ≪陶里≫ гэж хэлнэ гэсэн тэмдэглэл буй. Дээрх кидан үсгийн нэгдүгээр үсгийг [t'ɑu] гэж унших гуравдугаар үсгийг [ɑ] гэж уншихыг нэгэнт мэдсэн тул бүхэл үгийг [t'ɑuliɑ] гэж уншиж болно. Монгол хэлтэй төсөөтэй.

Зургаа. ≪Морь≫ гэх үгийг киданы бага үсгээр 又化 гэж бичдэг. Нэгдүгээр үсэг нь [m] гийгүүлэгчийг агуулж байхыг 付拥 又为 们 九习 尤 [piŋ mɑ tu kiem] (兵馬都監) зэргээс нэгэнт мэдсэн. Хойнох үсэг нь юу болохыг нотолсон зүйл харагдаагүй. Ийм байдалд монгол хэл хийгээд кидан хэлний дээр дурдсан нягт харьцаагаас дээрхи хагас нь mə~mo байж болох тул бүхэл үгий mori гэж төсөөлөөд хожмын шалгалтаар батлахыг бодсон юм. Хожмын шалгалтанд үүнийг эсрэг баримт гараагүй байсаар.

Долоо. ≪Могой≫ гэх үгийг киданы бага үсгээр 住礼及 гэж бичиж байдаг. Энэ гурван үсгийн дотроос хоёрдугаар үсэг нь. [g] буюу [gɑ] дуудлагатай байхыг мэдсэн (жишээ нь 牙礼 нь ≪geria≫ заах бөгөөд дуудлага нь [gɑ:g]. Гуравдугаар үсэг нь [o] болно (жишээ нь 令及 术坐 令节 нь so ʧ'əŋ siɑŋ 左

丞相 болох). Иймээс бүхэл үгийг mogo гэж төсөөлж болно. Үүний эсрэг жишээ гараагүй юм.

Найм. ≪Барс≫ гэх үгийг киданы бага үсгээр гэж бичиж байдаг. Түрүүчийн хоёр үсэгийг xaga гэж уншиж болохыг хэдийн мэдээд байсан. Гэвч сүүлчийн үсгийг уншиж чадаагүй. Монгол хэл төрөл хэлнээс үзэхэд бүхэл үгийг уншихын арга ч үгүй. Иймээс бусад талаас иш баримт эрэх хэрэгтэй болжээ.

Гуравдугаар үсгийг унших талаар судлаачдаас гурван зүйлийн санал гаргаж байсан. Бат нөхөр түүнийг ≪гөрөөс≫ гэж унших нь зүйтэй гэв. Лиу Пван Жу нөхөр өөр үсгийн уншлагыг ярьж байхдаа тус үсгийг [uŋ] гэж уншиж болно гэжээ. Ван Хун Ли нөхөр хэлэхдээ бүхэл үсгийг [xaɣa:s] гэж уншиж болно. Гэхдээ сүүлчийн [as] нь олон тооны дагаврыг илтгэнэ гэжээ. Миний үзэхээр бүхэл үгийг [xaga:s] гэж унших нь зүйтэй бөгөөд баримт нь дээр дурдсан гурван зүйлийн саналтай бүр адилгүй. Миний баримт гэвэл хоёр зүрвас буй. (1) ≪燕北条≫ (Яан Бэй орны тэмдэглэл) гэдэг номд ≪蔓珍思≫ (Лэү звэн сви) гэсэн үг байж. Тэр нь ≪баавгай барс≫-ыг заана гэв. ≪說郛 重編燕北条≫ (Шүвэ Пу дахин найруулсан Яан Бэй орны тэмдэглэл) гэдэг номд ≪番柯忍≫ (Фан гэ жен) хэмээх үг болбоос ≪луу, барс≫-ыг заамой гэж. Миний нарийвчлан хянаснаар энэхүү хоёр зүйлийн тэмдэглэлд бүр үсгийн буруу алдаа байх бөгөөд түүнийг ≪蔓柯思≫ (loukəsɿ) бол ≪луу барс≫ыг заана гэж засвал сая хамгийн анхны тэмдэглэлтэй нийцэх болно. (2) [lou] нь ≪луу≫-г зааж [kəsɿ] ~ [kasɿ] нь ≪xaga.as≫ заана. ≪xaga.as≫ нь ≪хаган асу≫ бололтой. Энэ ≪асу≫ нь монгор хэлний ≪асу≫ [a:sə], Дунсян хэлний ≪асун [asuŋ]≫-тай тохирно. Адгуус амьтныг заасан эртний монгол төрөлийн үг бололтой. Тэгээд тэр ≪хаган асу≫ гэхийг барс бол адгуус амьтний хаан гэсэн санаанаас улирч ирсэн гэж үзэж болох ба ≪хаган≫ гэх мэтийн үгний ≪а≫ нь гээгдэх нь хэлэн дэхь ердийн үзэгдэл болох ажээ.

Ес. Ойрын үе болтол киданы бага үсгийн материал дотор ≪гахай≫ гэдэг үгийн бичлэг ерөөс харагдахгүй байжээ. 1965 оны зун Бээжингийн Лиу Пвэн жу авгай надад захидал ирүүлж нэг баярын чимээ мэдэгдсэн нь саяхан Харчин хошуунаас олдсон хөшөө чулуунд ≪гахай≫ гэдэг үг гарсан бөгөөд түүнийг киданы бага үсгээр  гэж бичиж байна гэв. Энэ үсэг бол аль хэдийн хятад зээллэг үгэнд гарсан тул дуудлага нь wei болохыг

мэдээд байжээ. Иймээс ≪гахай≫-ыг кидан хэлээр wei гэж хэлэх нь тодорхой болжээ. Энэ нь алтай язгуурт бусад төрөл хэлнүүдээс бүр ч ондоо байна.

Арав. Ойрын үе болтол киданы бага үсгийн материал дотор ≪бичин≫ гэдэг ч ерөөс гаргадаагүй байжээ. Энэ жил (1997 он)ийн 3-р сард Бээжингийн хуучин судлах газар нь хуучны сан хөмрөгөө цэвэрлэн дэглэх үед тийш хагарсан хэдэн бага үсгийн хөшөө чулуу байсныг Лиу Фэн жү авгай очиж үзэхэд түүний дотор ≪бичин≫-ийг заасан кидан үсэг 北及 гэж байжээ. Одоо энэхүү хөшөөг Елиүй Диле-ийн онгоны тэмдэглэл (耶律迪烈墓志) гэж нэрлэж байна. ≪Бичин≫-г илтгэсэн дээрх гурван дан үсэг нь бүр танигдсан үсэг болох бөгөөд [po:]~[pʊ:] гэж уншиж болно. ≪Бичин≫-г уншиж дуудах нь мөн ч төрөл хэлнүүдийн дуудлагатай ондоо болжээ.

Арван нэг. ≪Үхэр≫-ийг илтгэх киданы бага үсэг нь 右 болохыг аль хэдийнээс мэдэж байсан боловч яаж уншихыг мэдэх аргагүй байжээ. Харин 90 онд Японы эрдэмтэн Тоёота авгай ≪киданы бага үсгийн орон байр хийгээд хэсэг тооны нэрийн тухай≫ (тосон дармал) гэдэг өгүүлэлдээ киданы бага үсгийn материал доторхи 丈 天初 令右 方女斗 гэсэн үсгүүдийг түүхийн тэмдэглэлийг үндэслэж ≪хоёрын өдрийн шөнө үхбэй≫ гэж орчуулжээ. Үүний доторхи хамгийн чухал нь ≪шөнө≫-ийг 夫另 гэж бичсэн хэрэг болно. Нэгдүгээр үсэг нь [s] болохыг нэгэнт мэдсэн тул хоёрдугаар үсэг нь [un] буюу [unj] байж мэднэ. Тэгвэл ≪Үхэр≫ гэсэн үгийг кидан хэлээр ≪un≫ буюу ≪unj≫ гэх мэтээр хэлсэн хэрэг болно. Ингэж дагах нь нөгөө элдэв хоёрын таамаглалаас илүү найдвартай гэж би хувьдаа итгэж байна. Бас нэг үг нэмж хэлбэл энэ ≪un≫ буюу ≪unj≫ гэдэг үг нь монгол хэлний ≪unee≫ гэсэн үгтэй үндэс нэгтэй үг болох байна.

Арван хоёр. ≪Хулгана≫ гэдэг үгийг киданы бага үсгээр 令右 гэж бичдэгийг аль хэдийн мэдээд байжээ. Хоёрдугаар үсгийг γ [ɢ] гэж уншихыг ч мэдээд байжээ. Гэвч бүхэл үгийг яаж уншихыг одоо болтол тодорхойлж чадаагүй. Бат нөхөр кидан хэлний ≪хулгана≫-ыг манж хэлний булга ≪seke≫-тэй гарал нэгтэй байж мэднэ гээд sæγ буюу sæγu гэж уншиж болно гэв. Ван Хун Ли нөхөр кидан хэлний ≪хулгана≫-ыг уйгур хэлний ≪洗尺罕≫ (高昌館朵字)-тай гарал нэгтэй байж [ʃɑʤkɑn] буюу [sɑʤkɑn]-аас улирч sɑrgɑ болсон байна гэв. Эдгээр үзэлт нь бүр анхааруштай зүйл болох боловч удаандаа нэг тийш хэлэхэд хэцүү шиг бодогдно. Хэдийбээр

тийм боловч түүний дуудлага нь монгол хэлнээс бүр ондоо болох нь харин тодорхой болжээ.

Дээр дурдсан зүйлүүдийг ерөнхийлбэл кидан хэлний 12 эрхтний нэрийн дотроос луу, тахиа, морь, могой, туулай, нохой, хонь (ямаа), үхэр (үнээ) зэрэг найм нь монгол хэлтэй адил буюу үндсэндээ адил байна. Барсын дуудлага нь ондоо боловч монголоор тайлж болно. Харин үлдсэн гахай, бич, хулгана гурав нь монгол хэлнээс бүрмөсөн ондоо болно. Энэхүү байдал нь монгол хэл хийгээд кидан хэлний адил тал хийгээд зөрөөтэй тал хоёр хэлний хоорондын харьцааг зарим талаар үзүүлсэн хэрэг болно.